



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 07 сарын 06 өдөр

дугаар 4/2016

Улаанбаатар хот

Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн
хяналтын хорооны бүрэлдэхүүнийг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24.2 дахь заалтыг үндэслэн
ТУШААХ нь:

1. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны гишүүн Д.Баярмаа, Ш.Цэрмаа нарыг тушаал гарсан өдрөөс эхлэн 2 жилийн хугацаатай, бусад гишүүдийг 3 жилийн хугацаатай томилон ажиллуулсугай.
3. Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороодын үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооны дарга (Д.Цэрэндагва)-д даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 270 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


САЙД



С.ЛАМБАА

081070

Эрүүл мэнд спортын сайдын
2016 оны 07 сарын 07 өдрийн
дугаар тушаалын хавсралт



Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын
хорооны бүрэлдэхүүн

- Хорооны дарга: Далхын Цэрэндагва, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Уламжлалт анагаахын төвийн захирал
- Орлогч дарга: Доржийн Баярмаа, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш
- Нарийн бичгийн дарга: Ядамын Амаржаргал, ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
- Гишүүд: Нямаагийн Тунгалаг, ЭМСЯ-ны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн мэргэжилтэн
- Цэрэнгийн Түвшинжаргал, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Био-Анагаахын сургуулийн захирал (хууль, эрх зүйн мэргэжилтний төлөөлөл)
- Дашзэвэгийн Цэцэгээ, "Хүрээ" амаржих газрын эмчилгээ эрхэлсэн орлогч дарга(эмчийн төлөөлөл)
- Даш-Яйчилын Эрдэнэдэлгэр, "Топаз" эмнэлгийн захиргаа, хүний нөөцийн албаны дарга (хувийн хэвшлийн эмнэлгийн төлөөлөл)
- Шаравын Цэрмаа, "Натул" эмнэлгийн сувилахуйн албаны дарга (сувилагч, тусгай мэргэжилтний төлөөлөл)